

Хэрэгжүүлж эхлэх хугацаа: 2006 оны 7 дугаар сарын 1.

Энэхүү хуулийн зорилго нь тамхины утааг хязгаарлах замаар Колорадо Муж Улсын оршин суугчдын эрүүл мэнд, ая тухтай байдал, байгаль орчныг хадгалах, хамгаалахад оршино.

Зөвхөн дор дурдсанаар хязгаарлагдахгүйгээр орчинг нь тамхины утаагүй байлгахыг шаардах газрууд:

- Цахилгаан шат, жорлон, үзвэрийн газар, музей, номын сан, боловсролын байгууллагууд, өндөр настны халамжийн газар, сувиллын газар зэрэг нийтийн зориулалттай газар, барилга байшин
- Лобби, хүлээлгийн танхим, коридор зэрэг нийтийн зориулалттай талбай
- Ресторан, баар, мөрийтэй тоглоомын зарим газар, билльяардын танхим, боулингийн тоглоомын газар, хүнсний дэлгүүр болон хүнсний үйлчилгээний бүх байгууллагууд
- Спортын дотор заал, бэлтгэлийн заал, үзэгчдийн танхим
- Эрүүл мэндийн үйлчилгээний газрууд, эмнэлэг, клиник, эмчийн өрөө, хүүхдийн ясли, цэцэрлэг
- Зочид буудал ба зочдод түрээсэлдэг унтлагийн өрөө бүхий мотелийн байрны 75-аас багагүй хувь
- Тангаргийн шүүгчдийн хүлээлгийн өрөө, зөвлөлдөх өрөө, шүүхийн тасалгаа, нийтийн өрөө
- Төрийн өмчийн нийтийн тээврийн бүх төрлийн хэрэгслүүд

### **Үүдний Талбай**

- Энэ хуулинд хамаарагдах бүх газруудын үүдний талбай тамхины утаагүй байх ёстой.
- "Үүдний талбай" гэдэгт холбогдох барилга байгууламж руу нэвтрэн орох гол хаалганы гадна талын талбайг ойлгоно. Энэ ойлголтод мөн хаалганаас гадагшаа тодорхой радиуст орших нийтийн болон хувийн зориулалттай талбай орно. Энэхүү талбайн радиусын хэмжээг орон нутгийн засаг захиргаанаас тогтоох ба хэрэв холбогдох байгууллага энэ талаар шийдвэр гаргаагүй бол уг талбайн радиусын хэмжээ 15 фийт байна.
- Орон нутгийн засаг захиргаанаас үүдний талбайн радиусын хэмжээг 15 фийтээс багаар тогтоож болно.

### Чөлөөлөгдөх Орчнууд

- Хувийн амьдах байр, барилгууд болон хүүхэд асрах буюу өдөр өнжүүлэх газрын хэрэгцээнд ашиглаж байгаагаас бусад хувийн тээврийн хэрэгслүүд
- Хувийн хэрэгцээнд хөлсөөр ашиглаж байгаа лимузин
- Зочид буудал, мотелийн байрны 25 хүртэлхи хувь
- Тамхи жижиглэн худалдаалах газрууд
- 2005 оны 12 сарын 31-ны өдрийн байдлаар "Тамхи, янжуур зөвшөөрөгдсөн баар" гэсэн тодорхойлолтыг хангах газрууд
- Дээр заасан үүдний талбайд хамаарагдахгүй байгууллагын гаднах талбай
- Казиногийн үйлчилгээний давхар
- Денверийн Олон Улсын Нисэх Онгоцны Буудлын бүрэн хаалттай, тусдаа агааржуулалттай тамхи татах зориулалтын тасалгаанууд
- Нийтийн зориулалттайгаар ашиглах талбай руу гарах боломжгүй гурав ба түүнээс доош тооны ажиллагсадтай ажлын орчин
- Жилд 500,000 ам. доллараас бага орлоготой тариалангийн ба мал аж ахуйн фирмийн хувийн өмчийн бөгөөд амьдрах зориулалтгүй барилга

### Шийтгэл

Энэхүү хуулийг зөрчсөн явдал нь 2 дугаар ангиллын бага хэмжээний зөрчилд тооцогдоно.

- Энэ хуулинд хамаарах газар, байрыг өмчилж, удирдаж, үйл ажиллагаа явуулж байгаа, түүнчлэн бусад хэлбэрээр хяналт тавьж байгаа этгээд энэ хуулийн ямарваа заалтыг зөрчсөнийг хууль зөрчсөнд тооцно.
- Энэ хуулиар тамхи татахыг хориглосон газарт тамхи татсаныг хууль зөрчсөнд тооцно.
- Календарын жилийн туршид 1 дэх удаагийн гаргасан зөрчилд – 200 ам. долларын торгууль
- Календарын жилийн туршид 2 дахь удаагийн гаргасан зөрчилд – 300 ам. долларын торгууль
- Календарын жилийн туршид 3 дахь удаагийн гаргасан зөрчилд – 500 ам. долларын торгууль тус тус ногдуулна.

Зөрчлийг үргэлжлүүлэн гаргаж буй өдөр тутамд тусад нь хариуцлага тооцно.

### Хууль Хэрэгжүүлж Эхлэх

- Энэхүү хуулийн хэрэгжилтийг орон нутгийн засаг захиргаа хариуцан хангана.